

Батлав. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тухайн асуудал хариуцсан газрын дарга _____ / _____ /

эсхүл (Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан газрын дарга _____ / _____ /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

ТҮМЭН ТАЛ ХХК-ийн гүйцэтгэх захирал _____ /Ч.Алтанхуяг/

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН "ГӨЛТГӨНИЙН ОРД" ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5547938/

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: МУ-022689

ХЯНАСАН:

БОАЖА-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН,
БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ

Ц. ЖАРГАЛНЭМЭХ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

“ТҮМЭН ТАЛ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч. АЛТАНХУЯГ

“ТҮМЭН ТАЛ” ХХК-ИЙН БХ-ИЙН АЖИЛТАН

А. ЭНХЖИН

2025 он

ГАРЧИГ:

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА
 - 1.1 Оршил
 - 1.2 Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал
 - 1.3 Ордын геологийн тогтоц
 - 1.4 2025 оны уулын ажлын төлөвлөлт
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА
 - 2.1 Уур амьсгал
 - 2.2 Физик, газар-зүй
 - 2.3 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл
 - 2.4 Хөрс
 - 2.5 Ургамлан бүрхэвч
 - 2.6 Нийгэм, эдийн засаг
3. “ТҮМЭН ТАЛ” ХХК-ИЙН ТӨСЛИЙН ТАЛБАЙД ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ
 - 3.1 Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ
4. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
 - 5.1 Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
 - 5.1.1 Тоос, тоосжилт бууруулах
 - 5.1.2 Уурхайн талбайд усалгаа хийх
 - 5.1.3 Гөлтгөнө тээвэрлэлтийн машинуудын хяналт
 - 5.1.4 Ашиглаж буй техник хэрэгслүүдийг автотээврийн хяналтын үзлэгт оруулах
 - 5.2 Гадаргын ба газрын доорхи усны нөөц
 - 5.2.1 Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, ус ашиглах гэрээ байгуулах, төлбөр төлөх
 - 5.3 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
 - 5.4 Газрын хэвлийд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө
 - 5.4.1 Олборлолтын улмаас газрын хэвлий эвдрэх, нөлөөлөлт өртөж доройтох
 - 5.5 Ургамлан нөмрөгт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

5.6 Амьтны аймагт учруулах сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө

5.6.1 Биотехникийн арга хэмжээ

6.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

6.1 Техникийн нөхөн сэргээлт

6.2 “Тербум мод” үндэсний хөдөлгөөн

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ

8.НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ

9. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

10. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

11.1 Агаарын чанарын хяналт шинжилгээ

11.2 Усны хяналт шинжилгээ

11.3 Хөрсний хяналт шинжилгээ

12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион
байгуулалтын төлөвлөгөө

13. 2025 оны байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн
оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

14. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: “Ширээ-Уул-2” гөлтгөний ордыг ашиглах төсөл

Төсөл хэрэгжүүлэгч: “Түмэн Тал” ХХК /РД: 5547938/

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол Роял Тауэр 1106 тоот

Утас: 99099048, 99899052

1.1 Оршил

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгалт орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг билээ.

1.2 Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

MV-022689 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Монгол улсын засаг захиргааны нэгжийн хувьд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутаг дэвсгэрт Ширээ уул нэртэй газарт орших Ширээ уул-2 гөлтгөнийн уурхай нь Улаанбаатар хотоос баруун урд зүгт 400 км, Дэлгэрхангай сумын төвөөс баруун урд зүгт 50 км зайд 38,31 га талбайг хамран байрлаж байна.

MV-022689 дугаартай тусгай зөвшөөрөлтэй талбай дараах солбицолд оршино.

№	Уртраг	Өргөрөг
1	104° 20' 47.11"	44° 59' 14.5"
2	104° 20' 20.11"	44° 59' 14.5"
3	104° 20' 20.11"	44° 59' 35.49"
4	104° 20' 47.11"	44° 59' 35.49"

Хүснэгт.1



Зураг 1. Байршлын тойм зураг

1.3 “Түмэн Тал” ХХК-ний ордын геологийн тогтоц

Ширээ уул-2 ордын талбайд дээд-дунд олигоцены настай ногоон, улаан хүрэн, хүрэн бор шавар, элсэн чулуу, хөрсөн чулуу, элс, элсэнцэр, шавханцар ба гөлтгөнө тархалттай байна.

Ордын баруун, баруун хойт хэсгээр гөлтгөнө агуулсан цайвар ногоон өнгийн шавар газрын гадаргууд тааралдах ба гөлтгөнө нь конкрец буюу судал хэлбэрээр тогтсон байдаг. Мөн ордын төв болон баруун урд талаар газрын гадаргуугийн хамгийн өндөрлөг хэсэг, жижиг гүвээ толгодын энгэр оройн хэсэгт тогтсон ногоон болон улаан хүрэн шаврын гөлтгөнөөр баяжигдсан хэсэг нь “шапка” байдалтай 50x200 м, 100x300 м хэмжээтэй биетийг үүсгэн тогтсон байдаг.

1.4 2025 оны уулын ажлын төлөвлөлт

Ашиглалтын жил	Ашигт давхарга	Гөлтгөнө	Хөрс хуулалт	Хөрс хуулалтын коэффициент
ОН	м3	тн	м3	м3/тн
2025	97.8	90,000	90.3	1

“Ширээ Уул-2” уурхай нь В-1 гэсэн гөлтгөнө агуулсан ашигт давхаргын геологийн блокуудаас 97.8 мян м³ гөлтгөнө агуулсан давхарга олборлож 90.1 мян м³ хөрс хуулж нийт 108.1 мян м³ (90.1 мян м³ x 1.2) сийрэгжсэн хөрсийг гадаад болон дотоод овоолгод хураана.

➤ Уурхайн ажиллах горим

Уулын ажлыг нийт 6 сарын хугацаанд явуулах ба уурхай нь 4 -р сарын 1-нээс эхлэн уурхайн бэлтгэл ажлууд болон хөрс хуулалтын ажлыг эхлүүлж 11-р сарын 15 хүртэл олборлох болон бутлан ангилах ажиллагааг явуулна.

Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарна. Харин техник, тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ, урсгал засвар хийх хугацааг сард 3 хоног байхаар ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгалаа.

- ✓ Жилд ажиллах хоног - 189 хоног
- ✓ Уулын ажлын ажлын хоног - 160 хоног
- ✓ Амралт, баяр ёслолын өдрүүд - 11 хоног
- ✓ Урсгал засвар хийх өдрүүд -24 хоног
- ✓ Ээлжийн тоо - 2 ээлж
- ✓ Ээлжинд ажиллах хугацаа - 140 цаг

➤ Ашиглалтын системийн сонголт

Уурхайн хуулах хөрсний зузаан 2.41 м, олборлох ашигт давхаргын зузаан 4.08 м байна. Шимт хөрсийг утгуурт ачигч ба автосамосвалын хослолоор тээвэрлэж овоолгод буулгана. Уурхайг тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системээр ажиллуулахаар сонголт хийлээ. Хөрс хуулалт болон ашигт давхаргын олборлолтын ажлыг ордын уул геологийн нөхцөлөөс хамааруулан уламжлалт технологи болох экскаватор – автосамосвалын хослолоор гүйцэтгэнэ. Гөлтгөний ашигт давхаргыг экскаватороор мөргөцгөөс өөрөө буулгагчид ачиж бутлан ангилах үйлдвэрийн дэргэдэх уриншуулах талбайд хүргэж, уриншуулах талбайн болон бутлан ангилах үйлдвэрээс гарсан шавар, хаягдлыг уурхайн дотоод овоолгод тээвэрлэнэ.





Зураг. Талбайн зураг

2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ширээ уул-2 гөлтгөний орд нь геологийн тогтоц, ашигт малтмалын нөөцийн хэмжээгээрээ гөлтгөний ордын нөөцийн ангиллын I бүлгийн 2-р төрөл гэсэн ангилалд хамаарах ба ашигт малтмал агуулсан хурдасны зузаан болон агуулга нь харьцангуй жигд тогтвортой байдаг.

2.1 Уур амьсгал

Дундговь аймгийн хувьд газрын гадаргын хотгор гүдгэрийн ялгаа төдийлэн их биш учраас аймгийн хэмжээгээр уур амьсгалын нөхцөл онцгой ялгардаггүй, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Намрын эхний гэнэтийн хүйтрэлт 10-р сарын дунд 10 хоногт тохиолдох ба зарим үед 9-р сарын дунд буюу эхний 10 хоногт болдог байна. Хүйтрэлгүй хоногийн тоо 125-135 хоногт үргэлжилдэг.

Эх газрын эрс тэс уур амьсгалтай учир хоногийн болон улирлын агаарын температурын хэлбэлзэл ихтэй агаарын дундаж бага температур нь 1-р сард -16.2 хэм, дундаж их температур нь 7-р сард +22.4 хэм байдаг ба жилд дундажаар 80 мм орчим чийг унадаг байна. Тус сум нь говийн бүс хангайн бүсийн дунд оршдог. Өвөлдөө 20-35 хэм хүйтэрч, зундаа 25-32 хэм халдаг. Хавартаа салхи их шуурдаг бөгөөд 5-25м/сек хүрдэг.

2.2 Физик, газар зүй

Тус төслийн талбай нь газар зүйн байршлын хувьд говийн бүсэд хамаарагдах бөгөөд өргөргийн дагуу 780-840 м-ийн үнэмлэхүй өндөршилтэй гүвээрхэг, дов толгодорхог гадаргуу үүсгэн тогтсон. Талбайн баруун талд орших Ширээ уулын үнэмлэхүй өндөр 1210м байна.

Тус район нь говь, хээрийн засварын бүсэд хамаарагдах ба энд тектоник-денудацийн, элэгдэл- хуримтлалын гэсэн хоёр гадаргуу ялгаж болно.

2.3 Ус зүй ба гидрогеологийн нөхцөл

Судалгааны талбайн районд тархсан газрын доорхи ус нь хөдөлгөөн болон хуримтлалын нөхцөлөөрөө давхрагын, ан цавын гэсэн хоёр төрөлд ялгагдана. Давхаргын ус нь ихэвчлэн дөрөвдөгчийн сэвсгэр хурдсанд агуулагдах ба ус агуулагч хурдас нь хайрга, хайрганцар, элс, элсэнцэр юм.

Ордоос баруун урагш 5км-т орших Цагаан усны уурхайн худаг нь давхаргын ус бөгөөд химийн найрлагаараа гидрокарбонат натрийн ангилалд багтах ба цэнгэгдүү, зөөлөвтөр ус боловч бохирдолт нь ундны усны стандартаас их байна. Ан цавын ус нь дунд рифейн настай хувирмал чулуулаг, дунд севон, доод пермийн настай гүний чулуулаг тархсан талбайд ан цав, тектоник хагарлыг дамжин үүссэн байдаг. Талбайгаас зүүн хойш 13км-т хуучин өрөмдсөн цооногоос ус даралтаас байнга урсан гарч байдаг ба энэ нь ан цавын ус бөгөөд олон жилийн турш хүн, малын ундны хэрэгцээг хангаж байна.

2.4 Хөрс

Талбайн ихэнх гадаргуу жижиг хэмхдэс агуулсан элсэрхэг хөрстэй, хотгор хоолой хэсэгт шаварлаг харс зонхилно.

2.5 Ургамлан бүрхэвч

Хотгор, хоолойнуудаар говийн тачир ургамал/хялгана/, бусад хэсэгт модлог, бутлаг харгана, шаваг ургасан байна.

2.6 Нийгэм, эдийн засаг

Төсөл хэрэгжүүлж буй талбай нь Монгол Улсын эдийн засгийн төвийн мужийн урд хэсэгт буюу Дундговь аймаг, Өмнөговь аймгийн заагт орших ба дэд бүтэц муу хөгжсөн, төв суурин газруудтай авто машины шороон замаар холбогдсон, холбоо харилцаа, цахилгаан эрчим хүчний системд холбогдоогүй зэлүүд газар байрладаг.

3. ТҮМЭН ТАЛ ХХК-ИЙН ТӨСЛИЙН ТАЛБАЙД ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Гөлтгөний ордыг ашиглаж дуусах үед 38,31 га талбайн үржил шимт хөрс хуулагдаж, ургамлын хөмрөгийн байдал, органик нэгдлийн хуримтлал устаж, хөрс ургамлын үе давхаргад тархан төлжиж амьдарч байсан бичил организм, шавьж хорхой, сээр нуруугүйтэн болон бусад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, амьдралын хэвийн тогтолцоо тодорхой хэмжээгээр алданана. Үүний нөлөөгөөр биогеоценозын тэнцвэрт байдал алдагдана.

Уурхайн үйл ажиллагааны явцад нэлээд хэмжээний тоос шороо босч ил гарсан гадаргуугаас салхиар зөөгдөн ойр орны ялангуяа салхины зонхилох салхины чиглэлийн дагуу хөрс ургамлыг дарж байгалийн өнгө төрхийг түр муутгах, ойролцоо амьдарч буй иргэдийн хэвийн амьдрах нөхцөлийг алдагдуулна. Мөн ургамлын ургалт, амьтны амьдрах орчин муутгах хүчин зүйл болно.

3.1 Байгаль орчны асуудал, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ

Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл:

Ил уурхайн олборлолтын үйл ажиллагааны явцад хөрс хуулалт, тээвэрлэлтээс ил задгай хөрснөөс хийссэн тоос нь орчны агаарыг бохирдуулах эх үүсвэр болж байна. Хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд агаарт дэгдэх тоосны хэмжээ харьцангуй их байгаа үед тоосжилт үүсгэж байгаа зам талбайд тоосжилтыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ..

Хөрсний эвдрэл, элэгдэл:

Хөрсөн бүрхэвч нь ил уурхай олборлолт, хөрс хуулснаар үржил шимт давхрага хөндөгдөх, газрын хэвлийгээс ухагдаж гарсан хөрсний овоолго нь газрын ландшафтад өөрчлөлт оруулж байгаа тул хөрсний элэгдэл эвдрэлийг бага байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, эвдэгдсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ, мөн шатах тослох материалын санамсаргүй алдагдлаас болж хөрс бохирдож болзошгүй учраас аюултай хог хаягдалын цэг байгуулна.

Усан орчинд үзүүлэх нөлөөлөл:

Уурхайн унд, ахуйн хэрэгцээний усыг уурхайн талбайгаас 10 км-т орших худгаас хангана. Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 2015-12-04-ний 259 тоот албан бичгээр Таргатын худгаас ус ашиглахыг зөвшөөрсөн. Уурхайд нэг ээлжийнд 10 хүн байрлаж ажилласан, барилгын ажил эрчимтэй биш байгаа тул хаягдал ус маш бага хэмжээтэй зөвхөн хоолны газраас гардаг.

Болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим

Ашигт малтмал олборлох, уул уурхайн үйлдвэрлэл явуулах үед байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, тэр нь эргэж нөлөөлөх эсэхийг болон нөлөөллийн үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодруулдаг.

Шууд нөлөөлөл:

Болзошгүй нөлөөллийн ихэнх нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Ил аргаар ашигт малтмал олборлохын тулд хөрс, хучаас хөрсийг хуулах, газрын хурдасыг эвдэж өөрчлөх, геологийн тогтоцыг нь шууд эвдэж өөрчлөх, газрын гадаргын нөөц баялагт хомсдол үүсэх зэргээс шалтгаалж экологийн тухайн орчны системд нөлөөлөх, байгалийн тэнцвэр, унаган төрх өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөллөөс сэргийлэн техникийн нөхөн сэргээлтийг байгалийн унаган төрхийг хэвээр хадгалах зарчмыг баримтлана.

Шууд бус нөлөөлөл:

Нэг дор олон хүнд механизм нэгэн зэрэг ажиллахад гарах дуу чимээ ихсэх зэрэг нөлөөлөл хамаарч байна. Дуу чимээнээс ажилчдын эрүүл мэндийг сэргийлэх зорилгоор дуу чимээний эрчмийг сулруулах чихэвч зүүлгэж хэвшүүлэх, амьтны үржлийн үед аль болох бага дуу гаргах шаардлагыг хэрэгжүүлж ажиллана.

Богино хугацааны нөлөөлөл:

Сөрөг нөлөөлөл

- Хүнд механизмуудаас агаарт бохир утаа хаягдах
- Агаарт тоос шороо дэгдэх
- Дуу шуугианы нөлөөгөөр ая тух алдагдах
- Гадаргын өөрчлөлт бичил орчны уур амьсгалд нөлөөлөх зэрэг нөлөөлөл хамаарч байна.

Иймд утаа тоос шорооны бохирдлыг багасгах зорилгоор дизель хөдөлгүүрийн утааны янданд шүүлтүүр тавих, ухагдсан хөрс шороо, машин механизмд талхлагдсан орчны газрыг ялангуяа авто замыг хуурайшилт ихтэй үед усалж, чийглэж байх, ахуйн хатуу, шингэн хог хаягдлын цэгийг хлораминаар тогтмол 7 хоногт 1 удаа ариутгаж, хуурай хог хаягдлыг Дэлгэрхангай сумын хогийн цэгт төвлөрүүлэн ажиллана.

Эерэг нөлөөлөл

- Татварын орлого
- Орон нутгийн иргэдэд ажлын байр бий болгох

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараах зорилтуудыг тавьсан.

Үүнд:

- ✓ Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарал хандуулах
- ✓ Хог хаягдлын хэмжээг бууруулах, эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх
- ✓ Уурхайн техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд гадаад болон дотоод овоолгыг хийж гүйцэтгэх
- ✓ Уурхайн ашиглалтын үед гал гарч болзошгүй хэсгүүдэд гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох
- ✓ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх уурхайн орчинд 200 ширхэг мод тарих
- ✓ Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгааллын арга хэмжээний хүрээнд Биотехникийн арга хэмжээ авч зэрлэг амьтдад /аргал, янгир/ өвс, хужирын тусламж, дэмжлэгийг үзүүлж ажиллана.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 5. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг	Эрх зүйн баримт бичиг
АГААРЫН ЧАНАР								
1	Уурхайн олборлолт болон уулын цул тээвэрлэх үйл ажиллагаанаас агаарт тоос үүсэх	Орчны агаарын чанарын хэмжилтийг хийлгэж, дүгнэлт гаргуулж байх	Гадаад, дотоод орчин	10 км	Жилд 2 удаа		Орчны чанар шинжилгэний хэсэгт тусгасан	Агаарын тухай хууль MNS 4585:2007 Агаарын чанар
2	Хүнд машин механизмын хөдөлгүүрээс ялгарах хорт хий нь гадаад орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Компанийн эзэмшлийн тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд хамруулна	Уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгсэл	-	Жилд 1 удаа		ҮАЗ	“Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг	Эрх зүйн баримт бичиг
								журам” ¹
3	Гөлтгөнө тээвэрлэлтээс тоосжилт, агаарын бохирдол үүсэх	Гөлтгөнө тээвэрлэж буй тээврийн хэрэгслийг бүтээлгэтэй ачуулах, түүнд хяналт тавих	Түгээлт, тээвэрлэлт ийн бүх тээврийн хэрэгсэл	Тогтмол	Үйл ажиллагааны турш		-	
	Нийт							
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж		Нийт зардал ₮	Эрх зүйн баримт бичиг
УСАН ОРЧИН								
1	Газар доорх усны нөөц хомсдох	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөх авах, ус ашиглах гэрээ байгуулах	Уурхайн хэмжээнд	2	2025 оны 1-р улиралд багтаана		Гэрээнд тусгагдасны дагуу	Усны тухай хууль

1

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг	Эрх зүйн баримт бичиг
2		Ус ашиглуулах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй ашиглах	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагаа ны турш		ҮАЗ	Усны тухай хууль
ХӨРС								
1	Уурхайн хэмжээнд хөрсний доройтол борхирдол үүсэх	Хөрсний овоолго болон шимт хөрсний овоолгын технологийн горимын мөрдөлтийг хангах	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагаа ны турш сар бүр		ҮАЗ	
2	Хог хаягдлын хуримтлал үүсч, орчны бохирдлыг нэмэгдүүлэх	Энгийн хог хаягдлыг зайлуулах гэрээг шинэчлэн байгуулж, хог хаягдлаа тогтмол хугацаанд Дэлгэрхангай сумын хогын цэгт буулгах	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагаа ны турш		ҮАЗ	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, давамж	Нэгж зардал, төг	Нийт зардал, төг	Эрх зүйн баримт бичиг
3	Ашиглаж буй газрын сул талбайн хөрс бохирдох	Хөрсний төлөв байдал, чанарын хяналтыг тогтмол хэрэгжүүлэх	Уурхайн хэмжээнд	-	Үйл ажиллагааны турш улиралд 1 удаа		ҮАЗ	
4	Тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийх	Төслийн талбайд	-	Тухай бүрт		-	Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5915:2008
АМЬТНЫ АЙМАГ								
1	Уурхайн үйл ажиллагаа, тээвэрлэлтээс	Тус бүс нутагт өвөлжилт, хаваржилт хүндэрч	Дэлгэрхангай сум	100-300	-		2,500,000	Амьтны тухай хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа, да втамж	Нэгж зардал,төг	Нийт зардал, төг	Эрх зүйн баримт бичиг
	Нутгийн зэрлэг амьтдын тоо толгой багасаж болзошгүй	лмаар зэрлэг амьтдын идэш тэжээл ховордох асуудал гардаг тул био-техникийн арга хэмжээ зохион байгуулах						
	Нийт дүн						2,500,000	

6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Шимт хөрсийг хуулах		га	< 2	ҮАЗ	II-IV улиралд	Газрын тухай хууль Газрын хэвлийн тухай хууль MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт
		Шимт хөрсийг тээвэрлэх						
		Ашиглагдсан орон зай, ухаш болон овоолгын гадаргууг хэвгийжүүлэн тэгшлэх						
		Шимт хөрсний овоолгыг хадгалах, хамгаалах						
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	Мод тарих болон бусад хөтөлбөр	Уурхайн орчинд	ш	200	2,000,000	II- IV улиралд	
Нийт						2,000,000		

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нийт зардал/төг/	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Амьтдын тоо толгой буурах, дайжих амьдрах орчин устах, идэш тэжээл нь хомсдохоос хамгаалах	Мэргэжлийн байгууллагын зөвлөгөө, дүгнэлтийг үндэслэн зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ төлөвлөж хэрэгжүүлэх	Дэлгэрхангай сум	2,500,000	Үйл ажиллагааны турш	
	Нийт дүн			2,500,000		

8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, эрүүл мэндийн аюулгүй байдал алдагдах	Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдлын журмууд, хөдөлмөр хамгааллын заавар, осол аваар гарах үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар дотоод сургалтыг тогтмол зохион байгуулах	Уурхайн хэмжээнд	-	ХАБЭА-н үйл ажиллагааны зардалд тусгасан	Жилд 2 удаа	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, MNS 4969:2000 стандарт, ХНХЯ-ны сайдын А/367 тоот тушаалын хавсралт журам
2	Байгалийн аюулт үзэгдэл, гамшигт нөхцөл байдал	Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөө. Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах	Уурхайн хэмжээнд	1	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Гамшгаас хамгаалах тухай хууль Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйл
		Барилга байгууламжийг газар хөдлөлийн бүсэд тохируулан хийцийг сонгох	Уурхайн ажилчдын кемп	1	ҮАЗ	Төслийн хүрээнд	

3	Гал түймрийн аюул, эрсдэл	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж түүнийг дагаж мөрдөх	Уурхайн хэмжээнд	1	ҮАЗ	Үйл ажиллагааны турш	Гамшгаас хамгаалах тухай хууль Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
4	Хүний эрүүл мэндэд нөлөөлөл үүсэх	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр хангах	Уурхайн ажилчид	-	ХХАЗардал	Үйл ажиллагааны турш	

9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Энгийн хог хаягдал	Сумын байгаль орчны хариуцсан мэргэжилтэн болон Сумын Засаг даргын тамгийн газартай жил бүр гэрээ байгуулж, хураамж төлөх	Ахуйн хог хаягдлын хэсэг	-	-	Сумаас тогтоосон тарифын дагуу	Төлбөрийг Жилд 1 төлөх	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3, 10.2.7
2		Уурхай дээр энгийн хог хаягдлаа ангилан ялгах	Ахуйн хог хаягдлын хэсэг	тн	10-12	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан	Тогтмол хэрэгжүүлэх	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.1
3		Шаардлага хангасан хогын савтай болгох	Ахуйн хог хаягдлыг хэсэг	-	-	ҮА-ны зардал	Жил бүр	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
4	Аюултай хог хаягдал	Шаардлага хангасан аюултай хог хаягдлын сав бий болгох	Аюултай хог хаягдал	ш	1	ҮАЗ	Жилдээ	Хог хаягдлын тухай хуулийн 21.1
5		Төсөлд ашиглагдаж байгаа аюултай хог хаягдлыг ангилаж гэрээ хийсэн байгууллагад тогтмол өгөх	Аюултай хог хаягдал	-	-	Гэрээний дагуу	Жилдээ	Хог хаягдлын тухай хууль

10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нийт зардал, төг	Тайлбар Баримтлах стандарт, арга, аргачлал
АГААРЫН ХЯНАЛТ						
1	Агаарын чанар, тоосжилт	Уурхайн кемпийн орчим Уурхайн карьерийн орчим	Жилд 2-3 удаа	2-3	500,000	MNS 4585:2016
ХӨРСНИЙ БОХИРДОЛ						
2	Хөрсний химийн ерөнхий шинжилгээ	Кэмпийн орчинд	Жилд 2 удаа	2	500,000	MNS3297:2019
3		Ашиглаж буй газрын сул хөрстэй хэсэг Нийт 2 хүртэлх цэгт	Жилд 2 удаа	2		MNS 5850:2019
УСНЫ ХЯНАЛТ						
4	Усны чанар, өнгө, рН, эрдэсжилт , нийт хатуулаг	Ашиглалтын худгын ойролцоох газраас	Жилд 2 удаа Улиралд 1 удаа	2	500,000	MNS 0900:2018
				2		MNS6561:2015
	Нийт				1,500,000	

11. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 11. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх
удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			I улирал	II улирал	III улирал		
БАЙГАЛЬ ОРЧНЫ УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО							
1	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж, биелэлтийг тайлагнаж ажиллах	ҮАЗ	Жил бүр төлөвлөгөөг өмнөх оны 01 сарын 01-ны дотор,хэрэгжилтийг 12 сарын 31-ний дотор			Төслийн менежер Уурхайн ээлжийн ахлах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах батлах, тайлагнах журам ¹⁴
2	Байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх	ҮАЗ	Үйл ажиллагааны турш			Төслийн менежер Байгаль орчны мэргэжилтэн	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹
ДОТООД ХЯНАЛТ							
4	Дотоод хяналт шалгалтыг боловсруулж, хэрэгжүүлж ажиллах	ҮАЗ	Жилд 2 удаа			Гүйцэтгэх захирал, Байгаль орчны мэргэжилтэн	
5	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулж, бууруулж ажиллах	ҮАЗ	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах			Гүйцэтгэх захирал, Байгаль орчны мэргэжилтэн	Зөрчил илэрсэн үед арилгах арга хэмжээг хэрэгжүүлнэ

12. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД
ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний
хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	Ерөнхий үнэлгээ хийсэн төрийн захиргааны төв байгууллага	Тухайн жилийн БОМТ-ний Хэрэгжилтийн тайлан, дараа оны БОМТ-г боловсруулан хүргүүлж, батлуулна.	БОАЖ-ын сайдын 2019 оны 10 сарын 29 өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын үйлдвэрлэлийн хэсгийн бүтцийг хамарсан байна.	Жил бүрийн 12 сард багтаана	ҮАЗ	Гүйцэтгэх захирал, Байгаль орчны мэргэжилтэн	БОАЖЯ-ны Хүрээлэн буй Орчин, Байгалийн Нөөцийн Удирдлагын газар
2	Дундговь аймгийн байгаль орчин, аялал зуучлалын газар	БОМТ-ний биелэлтийн тайланг хүргүүлнэ.		Жил бүрийн 11 сарын 01 дотор	ҮАЗ	Гүйцэтгэх захирал, Байгаль орчны мэргэжилтэн	
3	Нөлөөллийн бүсийн иргэн	Дунговь аймаг, УЦУОШГ-н ээлжит шинжилгээг хийхэд		Жилд 2 удаа	ҮАЗ		Уурхайн орчим

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
		нөлөөллийн бүсийн оршин суугч байлцуулах					

13. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨВ

Дундговь аймаг Дэлгэрхангай сумын нутаг дэвсгэрт байрлах “Түмэн Тал” ХХК-ийн 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10 сарын 29 өдрийн А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөнд 8,500,000 төгрөг зарцуулахаар тусгав.

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Төсөв/төг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө	2,000,000
2	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,500,000
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	500,000
4	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,500,000
5	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2,000,000
	Нийт	8,500,00



Шилжүүлгийн баримт

Сайн уу ?

таны Дижитал банкаар хийсэн шилжүүлгийн мэдээллийг илгээж байна.

Илгээгчийн / Sender's

Илгээгчийн банк
Sender bank
Данс/IBAN дугаар
Sender's / IBAN
account number
Дансны нэр
Sender's Account
Name

М БАНК

MN870039009005547938

ТҮМЭНТАЛ

Хүлээн авагчийн мэдээлэл / Receiver's

Хүлээн авагч банк
Receiving bank
Данс/IBAN дугаар
Receiver's / IBAN
account number
Дансны нэр
Receiver's Account
Name

ТӨРИЙН САН

MN780090100900013406

БО НӨХӨН СЭРГЭЭХ
БАТАЛГАА

Шилжүүлгийн мэдээлэл / Transaction details

Гүйлгээний дугаар
Transaction ID
Шилжүүлэг
хийсэн огноо
Transaction date
Утга
Transaction details

2025-06-26 SMB185058

2025-06-26 17:49:49

MV-022689 ТҮМЭН ТАЛ
ХХК ДУ.ДЭЛГЭРХАНГАЙ
БО НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН
БАРЬЦАА

Илгээсэн дүн
Sending amount
Хүлээн авсан дүн
Receiving amount
Ханш
Rate
Шимтгэл
Fee

5,000,000.00MNT

5,000,000.00MNT

₮ 250

2025 оны БО-ны нөхөн сэргээлтийн барьцаа төлбөр төлсөн баримт

